



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 02 өдөр

Дугаар А/115

Есөнбулаг

“Улсын хил хамгаалалтад туслах
хүчний орон тооны бус зөвлөл”-ийг
шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол улсын хилийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.2 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2000 оны 149 дүгээр зарлигаар баталсан “Улсын хил хамгаалалтад иргэдийг оролцуулах журам”-ын 1.3, 2.2, 2.4 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын дэргэд “Улсын хил хамгаалалтад туслах хүчний орон тооны бус зөвлөл”-ийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулж гишүүдийг хавсралтаар баталсугай.

2. Улсын хил хамгаалалтад дэмжлэг үзүүлж, аймгийн Улсын хил хамгаалалтад туслах хүчний зөвлөлтэй хамтран ажиллах “Улсын хил хамгаалалтад туслах хүчний орон тооны бус салбар зөвлөл”-ийг сумдад шинэчлэн байгуулж ажиллахыг Алтай, Бугат, Цогт, Тонхил, Эрдэнэ сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Улсын хил хамгаалалтад дэмжлэг үзүүлж ажлыг жил бүр төлөвлөгөө гарган зохион байгуулж ажиллахыг “Улсын хил хамгаалалтад туслах хүчний орон тооны бус зөвлөл”-ийн нарийн бичгийн дарга, аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т, Улсын хил хамгаалалтад туслах хүчний орон тооны бус зөвлөл-ийн гишүүд, “Улсын хил хамгаалалтад туслах хүчний орон тооны бус зөвлөл”-ийг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг “Улсын хил хамгаалалтад туслах хүчний орон тооны бус зөвлөл”-ийн орлогч дарга, Хилийн цэргийн 0214 дүгээр ангийн захирагч (хурандаа Э.Майдар)-т тус тус даалгасугай.

4. Улсын хил хамгаалалтад зориулсан нэмэгдэл зардлыг төсөвт тусгаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар, сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Г.Чинбат)-д даалгасугай.

6. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А/562 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

О.АМГАЛАНБААТАР



C:\My document ZAX A-4


8200010482

Аймгийн Засаг даргын 2024 оны
02 дугаар сарын 02-ны өдрийн 015 дугаар
захирамжийн хавсралт

**"УЛСЫН ХИЛ ХАМГААЛАЛТАД ТУСЛАХ ХҮЧНИЙ ОРОН
ТООНЫ БУС ЗӨВЛӨЛ"-ИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Зөвлөлийн дарга: Аймгийн Засаг дарга
Орлогч дарга: Хилийн цэргийн 0214, 0166 дугаар ангийн захирагч
Нарийн бичгийн дарга: Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга
Гишүүд:
Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн
бичгийн дарга (зөвшилцсөнөөр)
Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн
дарга
Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн
хэлтсийн дарга
Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын
хэлтсийн дарга
Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого,
төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга
Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга
Аймгийн Эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны
шүүхийн ерөнхий шүүгч
Аймгийн Прокурорын газрын Ерөнхий прокурор
Аймгийн Цагдаагийн газрын дарга
Аймгийн Онцгой байдлын газрын дарга
Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын
дарга
Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга
Эрүүл мэндийн газрын дарга
Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга
Мал эмнэлгийн газрын дарга
Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга
Тагнуулын ерөнхий газрын аймаг дахь хэлтсийн
дарга
Аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дарга
Говь-Алтай аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний
хэлтсийн дарга
"Мэдээлэл холбоо сүлжээ" ТӨХК-ийн аймгийн
салбарын дарга
Гаалийн хорооны дарга
Хилийн боомтын захиргааны боомт хариуцсан
төлөөлөгч
Говийн их дархан цаазат газрын "А" хэсгийн
хамгаалалтын захиргааны дарга
Говийн их дархан цаазат газрын "Б" хэсгийн

хамгаалалтын захиргааны дарга
Алтай сумын Засаг дарга
Бугат сумын Засаг дарга
Цогт сумын Засаг дарга
Тонхил сумын Засаг дарга
Эрдэнэ сумын Засаг дарга



--oOo--